



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/251-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: А.Гэрэлмаа

Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	Error! Bookmark not defined.
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Албан шаардлага, Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
НА	Нотлох ажил
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ОУБ	Олон улсын байгууллага



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг

Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040

E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/251-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-г

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖИЛ
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЗОЛЗАЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	263,108,715.28	268,523,981.04
33	АВЛАГА	-	46,441.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	46,441.00
35	БАРАА МАТЕРИАЛ	263,108,715.28	268,477,540.04
35100	Түүхий эд материал	129,317,709.75	128,962,826.97
35110	Тусгай зориулалттай материал	128,560,720.23	128,503,126.97
35130	Эм боох материал	756,989.52	459,700.00
35400	Хангамжийн материал	133,791,005.53	139,514,713.07
35410	Бичиг хэргийн материал	1,224,210.00	1,530,280.00
35420	Аж ахуйн материал	13,890,137.50	12,423,587.04
35430	Сэлбэг хэрэгсэл	60,000.00	60,000.00
35440	Түлш, шатах тослох материал	12,254,692.75	20,489,692.75
35450	Барилгын засварын материал	6,267,571.78	6,497,521.78
35460	Хүнсний материал	3,395,200.00	1,174,200.00
35470	Бусад хангамжийн материал	96,699,193.50	97,339,431.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,065,485,079.04	3,765,916,659.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,065,485,079.04	3,765,916,659.29
39200	Биет хөрөнгө	3,320,831,703.98	3,021,413,617.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,473,094,455.84	2,473,094,455.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(184,740,903.24)	(281,879,701.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	148,229,021.25	148,229,021.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	(73,738,000.66)	(96,535,438.58)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,022,332,441.42	1,031,568,841.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(293,263,992.78)	(460,081,923.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	206,616,334.97	208,339,542.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(125,611,480.98)	(148,602,703.13)
39214	Бусад үндсэн хөрөнгө	40,696,967.89	40,696,967.89
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,892,941.44)	(7,339,412.16)
39217	Ном	112,109,801.71	113,923,967.71
39300	Биет бус хөрөнгө	744,653,375.06	744,503,040.00
39301	Программ хангамж	15,408,000.00	15,408,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(15,126,624.94)	(15,276,958.19)
39303	Бусад биет бус хөрөнгө	744,372,000.00	744,372,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,328,593,794.32	4,034,440,640.33
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,328,593,794.32	4,034,440,640.33
51	Засгийн газрын хувь оролцоо	4,328,593,794.32	4,034,440,640.33
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,637,215,244.56	2,637,215,244.56
51200	Хуримтлагдсан үр дүн	(502,813,968.87)	(796,967,122.86)
51210	Өмнөх үеийн үр дүн	(221,645,269.67)	(503,060,329.41)
51220	Тайлант үеийн үр дүн	(281,168,699.20)	(293,906,793.45)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,194,192,518.63	2,194,192,518.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,328,593,794.32	4,034,440,640.33

2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,140,819,609.90	1,143,571,449.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,506,209.90	15,418,149.90
120	Нийтлэг татварын бус орлого	28,506,209.90	15,418,149.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,390,000.00	1,372,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,390,000.00	1,372,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	24,815,000.00	9,208,773.36
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	301,209.90	4,837,076.54
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,112,313,400.00	1,128,153,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,112,313,400.00	1,128,153,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,112,313,400.00	1,128,153,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,421,988,309.10	1,437,478,243.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,421,988,309.10	1,437,478,243.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,268,237,077.86	1,265,721,930.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	667,931,496.00	681,502,290.00
210101	Үндсэн цалин	449,882,744.00	365,103,653.00
210102	Нэмэгдэл	133,425,312.00	195,758,085.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,683,600.00	80,742,093.00
210104	Урамшуулал	47,939,840.00	39,898,459.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,766,986.76	89,802,780.05
210201	Тэтгэврийн даатгал	57,316,093.42	63,199,236.40
210202	Тэтгэмжийн даатгал	6,668,746.00	7,009,053.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,378,570.00	5,432,522.71
210204	Ажилгүйдлийн даатгал	5,142,926.00	1,287,451.55
210205	Эрүүл мэндийн даатгал	13,260,651.34	12,874,516.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,845,099.04	109,255,237.06
210301	Гэрэл, цахилгаан	21,202,739.00	17,516,500.06
210302	Түлш, халаалт	96,636,682.04	80,885,805.00
210303	Цэвэр, бохир ус	19,005,678.00	10,852,932.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,814,934.10	24,508,517.62
210401	Бичиг хэрэг	2,553,020.00	3,556,230.00
210402	Тээвэр, шатахуун	3,870,150.00	4,198,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,119,290.00	2,452,340.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,538,000.00	3,695,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,078,914.10	9,850,047.62

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	655,560.00	756,000.00
2105	Нормативт зардал	13,835,350.48	16,274,689.52
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	409,550.48	486,689.52
210502	Хоол, хүнс	13,425,800.00	15,788,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,315,150.00	4,056,480.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	369,600.00
210604	Урсгал засвар	2,315,150.00	3,686,880.00
2107	Томилолт, зочны зардал	1,280,200.00	821,600.00
210702	Дотоод албан томилолт	1,280,200.00	821,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,251,425.00	10,543,892.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,693,400.00	1,350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,752,000.00	8,059,996.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340,025.00	358,216.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	220,000.00	230,000.00
210807	Газрын төлбөр	246,000.00	545,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	330,196,436.48	328,956,444.21
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,776,424.90	16,860,611.64
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	317,420,011.58	312,095,832.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,751,231.24	171,756,312.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,381,200.00	117,371,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	91,184,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,007,700.00	24,686,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,373,500.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	107,370,031.24	54,384,712.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	107,370,031.24	54,384,712.89
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(281,168,699.20)	(293,906,793.45)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(281,168,699.20)	(293,906,793.45)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,115,703,400.00	1,129,525,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,390,000.00	1,372,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,390,000.00	1,372,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,390,000.00	1,372,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,390,000.00	1,372,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,112,313,400.00	1,128,153,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,112,313,400.00	1,128,153,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,112,313,400.00	1,128,153,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,114,177,400.00	1,125,960,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,114,177,400.00	1,125,960,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	960,426,168.76	954,204,287.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	662,076,689.84	681,548,731.00
210101	Үндсэн цалин	448,186,228.15	403,610,219.00
210102	Нэмэгдэл	134,493,547.00	166,329,096.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,941,817.69	73,848,300.00
210104	Урамшуулал	46,455,097.00	37,761,116.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,621,792.92	89,802,780.05
210201	Тэтгэврийн даатгал	63,186,909.88	63,199,236.40
210202	Тэтгэмжийн даатгал	6,685,550.76	7,009,053.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,263,533.41	5,432,522.71
210204	Ажилгүйдлийн даатгал	4,205,653.17	1,287,451.55
210205	Эрүүл мэндийн даатгал	13,280,145.70	12,874,516.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,711,180.00	119,245,237.06
210301	Гэрэл, цахилгаан	21,202,739.00	17,516,500.06
210302	Түлш, халаалт	95,502,763.00	90,875,805.00
210303	Цэвэр, бохир ус	19,005,678.00	10,852,932.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,166,215.00	16,415,485.00
210401	Бичиг хэрэг	2,182,150.00	3,563,950.00
210402	Тээвэр, шатахуун	5,655,150.00	2,443,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,119,290.00	2,452,340.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,262,000.00	2,340,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,947,625.00	5,615,295.00
2105	Нормативт зардал	18,338,000.00	14,531,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	509,400.00	189,400.00
210502	Хоол, хүнс	16,041,600.00	12,718,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,787,000.00	1,623,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,180,200.00	4,917,230.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,158,600.00	260,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	800,000.00
210604	Урсгал засвар	2,021,600.00	3,857,230.00

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	1,280,200.00	821,600.00
210702	Дотоод албан томилолт	1,280,200.00	821,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,655,125.00	10,543,892.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,693,400.00	1,350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,752,000.00	8,059,996.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340,025.00	358,216.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	220,000.00	230,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	403,700.00	-
210807	Газрын төлбөр	246,000.00	545,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,396,766.00	16,378,332.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,396,766.00	16,378,332.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,751,231.24	171,756,312.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,381,200.00	117,371,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	91,184,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,007,700.00	24,686,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,373,500.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	107,370,031.24	54,384,712.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	107,370,031.24	54,384,712.89
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,526,000.00	3,565,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,526,000.00	3,565,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,526,000.00	3,565,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,526,000.00	3,565,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,526,000.00	3,565,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,526,000.00)	(3,565,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	2,620,415,244.56	2,194,192,518.63	(214,008,889.11)	4,600,598,874.08
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(7,636,380.56)	(7,636,380.56)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,620,415,244.56	2,194,192,518.63	(221,645,269.67)	4,592,962,493.52
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	16,800,000.00	-	-	16,800,000.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(281,168,699.20)	(281,168,699.20)
10	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	2,637,215,244.56	2,194,192,518.63	(502,813,968.87)	4,328,593,794.32
11	2021 оны 1-р сарын 1-нээрс үлдэгдэл	2,637,215,244.56	2,194,192,518.63	(502,813,968.87)	4,328,593,794.32
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(246,360.54)	(246,360.54)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,637,215,244.56	2,194,192,518.63	(503,060,329.41)	4,328,347,433.78
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(293,906,793.45)	(293,906,793.45)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,637,215,244.56	2,194,192,518.63	(796,967,122.86)	4,034,440,640.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,132,253,300.00	1,075,140,887.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,132,253,300.00	1,075,140,887.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,013,282,900.00	957,769,287.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	711,797,500.00	681,548,731.00
210101	Үндсэн цалин	423,439,600.00	403,610,219.00
210102	Нэмэгдэл	175,201,900.00	166,329,096.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,368,000.00	73,848,300.00
210104	Урамшуулал	40,788,000.00	37,761,116.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,197,800.00	89,802,780.05
210201	Тэтгэврийн даатгал	69,805,800.00	63,199,236.40
210202	Тэтгэмжийн даатгал	7,348,000.00	7,009,053.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,878,400.00	5,432,522.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,469,600.00	1,287,451.55
210205	Эрүүл мэндийн даатгал	14,696,000.00	12,874,516.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,083,300.00	119,245,237.06
210301	Гэрэл, цахилгаан	19,978,600.00	17,516,500.06
210302	Түлш, халаалт	90,904,700.00	90,875,805.00
210303	Цэвэр, бохир ус	16,200,000.00	10,852,932.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,708,900.00	16,415,485.00
210401	Бичиг хэрэг	3,666,300.00	3,563,950.00
210402	Тээвэр, шатахуун	4,461,800.00	2,443,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,240,400.00	2,452,340.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,679,400.00	2,340,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,661,000.00	5,615,295.00
2105	Нормативт зардал	18,854,800.00	14,531,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	189,400.00	189,400.00
210502	Хоол, хүнс	17,040,000.00	12,718,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,625,400.00	1,623,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,501,000.00	8,482,230.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,843,700.00	3,825,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	3,857,300.00	3,857,230.00
2107	Томиллолт, зочны зардал	935,700.00	821,600.00
210702	Дотоод албан томиллолт	935,700.00	821,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,713,700.00	10,543,892.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,350,000.00	1,350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,060,000.00	8,059,996.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	473,700.00	358,216.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	230,000.00	230,000.00

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210807	Газрын төлбөр	600,000.00	545,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,490,200.00	16,378,332.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,490,200.00	16,378,332.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,970,400.00	117,371,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	118,970,400.00	117,371,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	1,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,184,700.00	91,184,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,686,900.00	24,686,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,098,800.00	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,132,253,300.00	1,075,140,887.11
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,128,153,300.00	1,073,768,587.11
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,128,153,300.00	1,073,768,587.11
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,100,000.00	1,372,300.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,100,000.00	1,372,300.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	107	107
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	53	53
620001	Удирдах ажилтан	3	1
620002	Гүйцэтгэх ажилтан	31	33
620003	Үйлчлэх ажилтан	19	19
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	53	53
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	28	31
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	25	22

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв /цаашид Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв гэх/ -ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарын аудитор А.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь “Багш, ажилтан, суралцагчдын мэргэжил, ур чадварыг байнга дээшлүүлж тэдний ажиллах ая тухтай таатай орчинг бүрдүүлж ажиллах” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах,
- Хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах,
- Үйлдвэрлэл дээр мэргэжлийн сургалт зохион байгуулах,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах босго үнийг “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор шинэчлэн хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дээд шатны төсвийн захирагч болох Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,437,478.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,374.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 10,062.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 294,153.1 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Нийгмийн даатгалаас авах авлага	-	46.44	46.44
Татаас санхүүжилтийн авлага			
Байгууллагаас авах авлага			
Урьдчилж төлсөн зардал			
Бараа материал	263,108.72	268,477.54	5,368.82
Үндсэн хөрөнгө	4,065,485.08	3,765,916.66	(299,568.42)
Нийт хөрөнгө	4,328,593.79	4,034,440.64	(294,153.15)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,328,593.79	4,034,440.64	(294,153.15)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,328,593.79	4,034,440.64	(294,153.15)

Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн 46.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,368.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хүнсний материал, аж ахуйн материал, хангамжийн материалын зарцуулагдаагүй үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 12,773.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр нийт 3,160.0 мянган төгрөгийн камер болон дагалдах бичигч хард, 250.0 мянган төгрөгийн зөөврийн хард, 155.0 мянган төгрөгийн болор баримт үдэгч худалдан авч, Эерэг өөрчлөлтийг хамтдаа НҮТББ-аас 972.2 мянган төгрөгийн ном, ХНХЯ-наас 841.9 мянган төгрөгийн ном, 5,271.4 мянган төгрөгийн өртөг бүхий 2 принтер, Дэлхийн зөн ОУБ-аас 1,723.2 мянган төгрөгийн өртөг бүхий тавилга, Сэлэнгэ аймгийн Онцгой комиссоос 400.0 мянган төгрөгийн 2 дижитал халуун хэмжигч зэрэг хөрөнгүүдийг хандиваар авч үнэ төлбөргүй орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,034,440.6 мянган төгрөг болж 294,153.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,143,571.5 мянган төгрөг болж өмнөх оноос 2,751.8 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,437,478.2 мянган төгрөг болж өмнөх оноос 15,489.9 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн. Энэ нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 4 ажилтанд нийт 91,184.7 мянган төгрөгийг олгосноос голлон нөлөөлсөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 2,159,554.5 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 992,911.4 мянган төгрөгөөр бууруулж 1,166,643.1 мянган төгрөгөөр баталсан байна. Ковид-19 цар тахлын улмаас мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв бүрэн хичээллээгүйтэй холбоотой төсөвт өөрчлөлт оруулж 34,389.8 мянган төгрөгөөр бууруулан **1,132,253.3** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,132,253.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,128,153.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,100.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,128,153.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 1,372.3 мянган төгрөг, нийт 1,129,525.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,075,140.9 мянган төгрөгийг зарцуулж 54,384.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,075,140.9** мянган төгрөг буюу 94.9 хувьтай тайлагнагдсан байгаа нь тогтмол зардал 35,046.5 мянган төгрөгөөр, цалингийн зардал 53,248.8 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 9,395.0 мянган төгрөгөөр, нормативт зардал 27,533.8 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 1,036.9 мянган төгрөгөөр, томилолтын зардал 348.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 319.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус төв нь нэмэлт санхүүжилтийн дансаар орлого бүрдүүлээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” үлдэгдэлтэй болсон 101,065.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 40 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “...

дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаа ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

3.7.2 Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг **улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ**”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 3.1-д “Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно” 3.1.4: “Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтнаар 1996 оны 8 дугаар сарын 1-нээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа” гэж зохицуулсан байдаг.

Гэтэл өндөр насны тэтгэвэр тогтоолгосон Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн галч Г.Батхүүгийн Мод боловсруулах комбинатад ажиллаж байсан 5 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, буцалтгүй тусламж олгохоор захирлын 2021 оны Б/54 дүгээр тушаалаар 12,499.8 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Мод боловсруулах комбинат нь улсын төсөвт үйлдвэрийн газар мөн эсэх талаарх эрсдэл үүсгэж байгаа учир төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж, тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь тайлант оны үйл ажиллагаанд **1,132,253.3** мянган төгрөг зарцуулахаар төлөвлөгдсөн ба гүйцэтгэлээр **1,075,140.9** мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 5.0 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 7,188.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 12,773.8 мянган төгрөгийн шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 53,389.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3,160.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 1,792.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 48,437.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3,160.0 мянган төгрөгийн 10 ширхэг дотор камер, бичигч, хард зэрэг тоног төхөөрөмжийг орлогод авахдаа программ хангамжийн дансанд тусгасныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр захирал Д.Очирбатад 1,792.2 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.7-д “*Энэ журмын 4.3-т заасан нөхцөлийг хангасан багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана. Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана.*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэргүйгээр олгосон улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. **Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

1.1 **Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд**

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 48,437.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ*” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв	4	53,389.3	1	3,160.0	1	1,792.2	1	-	1	48,437.1